



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/128

Алтай хот

Төсөл сонгон шалгаруулах хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдээс ирсэн төслийг сонгон шалгаруулах хорооны гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Хорооны дарга: (аймгийн Засаг даргын орлогч)
- Гишүүд: (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
- (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
- (Төрийн бус байгууллагын төлөөлөл)
- (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: (Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

2. Үйлдвэрлэл эрхлэгчдээс ирүүлсэн төслийг журмын дагуу үнэлэн, төслийг Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг хорооны даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/572 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

